

ГАДААД ХЭРГИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 03 дугаар
сарын 11-ны өдөр


Дугаар 1128 А/55

Улаанбаатар
хот

Монгол Улсын визийн загварыг батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11.7-д заасныг үндэслэн
ТУШААХ нь:

1. Монгол Улсын визийн загварыг 1 дүгээр хавсралтаар, визийн хуудсанд тэмдэглэх мэдээллийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Загварт өөрчлөлт оруулах тухай” Гадаад хэргийн сайдын 2001 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 80 дугаар тушаалын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.
3. Энэ тушаалыг 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.



9/28 A/55
Гадаад хэргийн сайд, Хууль зүйн сайдын
2015 оны 13 дугаар сарын 1-ний өдрийн
13 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт
МОНГОЛ УЛСЫН ВИЗИЙН ЗАГВАР

MONGOLIA MNG2587867

DUPLICATE



MONGOLIA MNG2587867

DUPLICATE



Гадаад хэргийн сайд, Хууль зүйн сайдын
2015 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
А/28 А/55 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

ВИЗИЙН ХУУДСАНД ТЭМДЭГЛЭХ МЭДЭЭЛЭЛ

1. Монгол Улсын визийн хуудас нь 7x11 см хэмжээтэй байна.
2. Хуудасны дээд хэсэгт "MONGOLIA" гэсэн бичиг байна.
3. Хуудасны баруун дээд буланд "MNG" гээд 7 оронтой дугаар байна.
4. Хуудасны зүүн дээд буланд "Монгол Улсын төрийн сүлд" байрлуулна. Төрийн сүлд нь нууцлалын хувирдаг өнгөтэй байна.
5. Хуудасны гол хэсэгт Монгол Улсын газрын зургийг дурсэлж дэвсгэр хийнэ. Голд нь соёмбо байрлуулах бөгөөд энэ нь тусгай төхөөрөмжөөр өнгө ялгарах нууцлалтай байна.
6. Хуудасны баруун гол хэсэгт 3x4 см хэмжээтэй цээж зураг байрлуулах зай байна.
7. Визийн хуудсан дээр паспортын дугаар, визийн хүчинтэй байх хугацаа, байх хугацаа, зэрэг, ангилал, зориулалт, төрөл, визийн тэмдэглэл, олгосон газар, олгосон огноо, эцэг /эх/-ийн нэр, нэр, хүйс, иргэний харьяалал зэргийг бичнэ.